Эд хогшил худалдан авах	715,300.00	715,300.00	-	100.0
Урсгал засвар	715,300.00	715,300.00	-	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	542,465,200.00	541,620,068.26	(845,131.74)	99.8
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	542,465,200.00	541,620,068.26	(845,131.74)	99.8
Орон нутгийн төсвөөс	542,465,200.00	541,620,068.26	(845,131.74)	99.8

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСДЫН ТОО	79	79	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	44	44	-	100.0
Үйлчлэх ажилтан	34	34	-	100.0
СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	420	392	(28)	93.3

2.8 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	75,154,988.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	-	75,154,988.00
210	Бараа, үйлчилгээний зардал	-	75,154,988.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	30,005,421.00
210101	Үндсэн цалин	-	24,319,252.00
210102	Нэмэгдэл	-	5,686,169.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,412,038.00
210201	Тэтгэврийн даатгал	-	2,412,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	9,678,600.00
210401	Бичиг хэрэг	-	1,349,600.00
210402	Тээвэр (шатахуун)	-	5,495,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	-	2,833,500.00
2106	Эд хогшил худалдан авах	-	16,114,856.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,218,000.00
210602	Тавилга	-	1,100,000.00
210604	Урсгал засвар	-	11,796,856.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,212,000.00
210702	Дотоод албан томилолт	-	1,212,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	-	8,753,003.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	8,745,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	8,003.00
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,979,070.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,152,820.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	5,826,250.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	75,154,988.00

**Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	75,154,988.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	41,029,889.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	33,625,099.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	79	79
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	44	44
620003	Үйлчлэх ажилтан	34	34
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллеж нь “Хүний нөөцийг мэргэшүүлж, чадварлаг мэргэжилтэн бэлтгэх” эрхэм зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллеж нь Боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол сургалтын тухай: Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авьяас, чадварыг харгалзан хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжил олгох, техникийн боловсрол эзэмшүүлэх, ур чадварыг нь дээшлүүлэх үүрэг бүхий байгууллага мөн. Техникийн боловсролын сургалтын байгууллагын хэв шинж нь политехник коллеж байна гэж заасантай нийцэж байна.

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллеж нь 2022 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяаллаас Боловсрол Шинжлэх Ухааны яаманд шилжсэн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль /2022 оны 4 дүгээр сарын 2-ний өдөр батлагдсан./
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.
4. Засгийн газрын 2022 оны 252 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал” хэсэгт өөрчлөлт оруулан 4.4.2-т ерөнхий боловсролын сургуулийн багшид мөнгөн урамшуулал олгох шалгуур, үзүүлэлтийг тогтоосон.
5. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7-д “Суутган төлөгч нь албан татвар төлөгчийн энэ хуулийн 21.1-д заасны дагуу ногдох албан татвар, 23.1-д заасны дагуу эдлэх хөнгөлөлтийг жилийн эцсийн тайлангаар эцэслэн тооцож тайлагнан, холбогдох татварыг төсөвт шилжүүлнэ”
6. Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 122 дугаар тогтоолоор “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдад тэтгэлэг олгох журам”-ыг баталсан.
7. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Загийн газрын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоол
8. “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль/дотуур байрын хүүхдэд хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх журам”-ыг батлах тухай Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/59 дүгээр тушаал
9. Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай Сангийн 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал.

Байгууллагын дотоод хяналтын талаар

Боловсролын ерөнхий газрын даргын 2022 оны 6 дугаар сарын 22-ны А/116 дугаар тушаалаар томилсон хяналт-шинжилгээ дотоод аудитын ажлын хэсэг нь батлагдсан удирдамжийн дагуу хяналт-шинжилгээ, дотоод аудитыг гүйцэтгэж гүйцэтгэлийн үнэлгээг 90 хувийн хэрэгжилттэй дүгнэсэн байна.

Байгууллагын дотоод хяналт баталгаажуулалт хариуцсан ажилтан нь 2022 онд нийт 6 зорилт 29 арга хэмжээг төлөвлөн сургалт, санхүү, эрсдэлийн үнэлгээ, бусад асуудлын талаар хяналт-шинжилгээ хийж тухай бүрд зөвлөмж өгч ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод аудитын үйл ажиллагаа нь үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-т заасны дагуу иж бүрэн ирүүлсэн.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

Санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС, хууль, тогтоол, тушаал, заавруудын өөрчлөлтийг тусгаагүй, байгууллагын удирдлагын тушаал шийдвэрээр батлаагүйгээс НБББББ-ийг өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны 1 дүгээр сараас 4 дүгээр саруудад тогтмол зардал, үйлчилгээний ажилтнуудын цалин, шимтгэлийг орон нутгийн төсвөөс, бусад зардлуудыг улсын төсвөөс санхүүжүүлж ирснийг, 2022 оны 5 дугаар сараас төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан цахилгаан эрчим хүч, халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардлыг орон нутгийн төсвөөс, бусад зардлыг улсын төсвөөс санхүүжүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 574,713.0 мянган төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

**Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	4,069.7	12,353.0	8,283.4
Бараа материал	244,269.6	273,771.1	29,501.5
Үндсэн хөрөнгө	6,421,126.8	5,803,629.0	(617,497.8)
Нийт хөрөнгө	6,669,466.1	6,094,753.0	(574,713.0)
Өр төлбөр	3,041.2	14,562.3	11,521.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,666,424.8	6,080,190.7	(586,234.1)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,669,466.1	6,094,753.0	(574,713.0)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс өмнөх оноос нэмэгдэж, бараа материал, өглөг буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд авлагын үлдэгдэл 8,283.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НҮБ-ын төслийн санхүүжилт 8,820.0 мянган төгрөгийн орлого орж ирсэн санхүүжилтийн хэрэгжилт гараагүй учраас Сангийн яаманд төвлөрүүлсэн, НДШ-ын авлага 234.6 мянган, 3,298.4 мянган төгрөгийн хувь хүмүүсээс авах нөлөөлсөн байна;
2. Үндсэн хөрөнгө өмнөх оноос 617,497.8 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн Төв аймгийн Баянчандмань сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 01 дугаар тогтоол 36,213.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгаснаас нөлөөлсөн;
3. Бараа материал өмнөх оноос 29,501.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 396,838.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдэж, 367,336.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Өглөг 11,521.0 мянган төгрөгөөр буурсан нь 2020, 2021 онд хэмнэгдсэн төслийг орон нутгийн гэрэл цахилгааны зардалд нэмж тусгаж өгөөгүй, байгууллагад өгөх өглөг өссөнөөс нөлөөлсөн;
5. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,080,190.7 мянган төгрөг болж, 586,234.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурсантай тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,395,283.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,395,283.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 69,446.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,424,831.4 мянган төгрөгөөр төсвийг баталсан байна. Энэ нь Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн төсвийн захирагч төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

**Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 69,446.2 мянган төгрөгөөр нэмж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,395,283.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,847,111.9 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 542,465.2 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах үйл ажиллагааны орлогоос 84,003.4 мянган төгрөгийн орлоготой ажиллаж, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 48,749.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,424,831.4 мянган төгрөг буюу 98,4 хувьтай байгаа нь нормантивт зардлын төсвийг 52.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийг 385.9 мянган төгрөгөөр, цалин хөлс, шимтгэлийн зардлыг 39,427.4 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
1	80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	1,503,273.0	1,464,522.0	(38,751.0)	97.42%
2	80219-Харуул хамгаалалтын зардал	55,200.4	54,895.8	(304.6)	99.45%
3	80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж	70,640.5	70,640.5	-	100.00%
4	81806-Дотуур байрны үйлчилгээ	217,998.0	217,998.0	(0.0)	100.00%
5	НҮБ-ын төсөл	8,820.0	-	(8,820.0)	0.00%
6	Туслах үйл ажиллагааны орлого	28.5	-	(28.5)	0.00%
Дүн		1,855,960.4	1,808,056.3	(47,904.0)	97.4%
Орон нутгийн төсвөөс					
1	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	498,887.3	498,887.2	(0.1)	100.00%
2	80112-Нийтлэг үйлчилгээ	43,577.9	42,732.9	(845.0)	98.06%
Дүн		542,465.2	541,620.1	(845.1)	99.80%
Нийт дүн		2,398,425.6	2,349,676.4	(48,749.2)	98.0%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 75,155.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 30,005.4 мянган, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 2,412.0 мянган, хангамж бараа материалын зардалд 9,678.6 мянган, эд хогшил худалдан авахад 16,114.9 мянган, томилолт зочны зардалд 1,212.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 6,979.1 мянган төгрөгийн зардлыг олгосон байна.

**Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав..

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Төв аймгийн Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллеж НҮБ-ийн 3 төсөл хөтөлбөр хэрэгжсэн байна.

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа		Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
		Эхэлсэн	Дууссан				
1	НҮБХХ-ийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн төлөвлөлтөөр хөдөлмөр эрхлэлтийн шинэчлэлийг дэмжих нь төсөв	8/17/2021	1/31/2022	Бүрэн хөдөлмөр эрхлэлт бүхий жишиг сум, дүүрэг	18,970.0	18,970.0	18,970.0
2	НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн Сургалтын байгууллагын хөтөлбөр мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсөв	2/9/2022	10/24/2022	Хөдөө аж ахуйн машин механизмын ашиглалт засварчин сургалтын хөтөлбөр, сургалтын хэрэглэгдэхүүн, үнэлгээний багцыг боловсруулах	26,994.5	26,994.5	26,994.5

/мянган төгрөгөөр/

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	НҮБ-ийн тогтвортой хөгжлийн зорилттой уялдсан төсвийн Сургалтын байгууллагын хөтөлбөр мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах төсөв	5/23/2022	12/10/2022	Зохистой хөдөлмөр эрхлэлт бүхий сум, дүүргийн туршилтыг санаачлан үйлчлүүлэгчид суурилсан үйлчилгээний загвар болон ажилгүйчүүд, ажил хайгчдыг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгод чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төсөл	17,640.0	29,400.0	17,640.0
---	---	-----------	------------	--	----------	----------	----------

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зорилготой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн ахлах Г.Ариунбат, аудитор Д.Буянравжих, О.Эрдэнэчимэг, шинжээч Б.Ган-Эрдэнэ, Т.Оюун, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторов туслах З.Ариунцэцэг, Г.Ариунболд нар гүйцэтгэж, чанарын хяналтыг чанарын хяналтын мэргэжилтэн С.Сождимаа, захирал С.Тунгалаг, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер О.Амаржаргал, Дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 05/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийн гүйцэтгэлийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 2022 оны жилийн батлагдсан төсвийн нийт зардлын 2,345,998.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 23,459.9 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, 34,280.6 мянган төгрөгийн хэмнэлт гарган ажилласан боловч орон нутгийн төсвөөс санхүүждэг гэрэл, цахилгааны зардлыг 2,434.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 155 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 51,419.8 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 62,014.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 16 удаагийн 21,255.8 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянчандмань сум дахь Политехник коллежийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудитыг хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитыг “Гэрэлтэх бүртгэл Аудит” ХХК гүйцэтгэж, 4 зөвлөмж, 3,706.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 9,739.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,481.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгснөөс 3 актын төлбөрийг бүрэн барагдуулсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	3,706.3	3	3,706.3	100%
Албан шаардлага	1	9,739.3	1	9,739.3	100%
Зөвлөмж	4	3,481.2	3	3,481.2	75%
Нийт дүн	8	16,926.8	7	16,926.8	91.67%

Өмнөх аудитаар дараах зөвлөмж, албан шаардлагаар өгсөн алдаа, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

Албан шаардлага:

1. Худалдан авалтыг татварын цахим системд бүртгээгүй, төлбөрийн баримтын цахим системээр нотлогдохгүй гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага дээр ажиллаж хөрөнгийн биет тооллого хийх нөхцөл байдал хязгаарлагдмал байснаас биет тест хэрэгжүүлээгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 6,674,366.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 6,674,366.1 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Үүнд: **Залруулсан алдаа:**

1. Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад төслийн сургалтад хамрагдсан зардал болох 4,900.0 мянган төгрөгийг цалингийн зардалд бүртгэсэн, гарт олгох дүнг залруулсан;
2. Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 6,669,466.1 мянган төгрөгийг залруулсан.

Аудитаар нийт 14,616.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 14,141.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 475.3 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Төлбөрийн акт

1. Шалгадагч байгууллагын хүүхдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 13,821.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байгаа нь Монгол Улсын засгийн газрын 83 дугаар тогтоолын 1-д "Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байранд амьдрах нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 3000 (гурван мянган) төгрөгөөр тогтоосугай." санхүүгийн тайлагналын аудитын "Эрх ба үүрэг", "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалын хавсралт "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасны дагуу Төлбөрийн акт тогтоосон.

2. Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 10 хүнд 190.0 мянган төгрөгөөр илүү тооцсон байгаа нь Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4.1-т "Тухайн тайлант жилийн 12 сард бүрэн тухайн байгууллагад харьяалагдаж ажилласан ажилтанд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг мөн хуулийн 27.1-д заасны дагуу жилийн эцэст өссөн дүнгээр тооцож, зөрүүг залруулж тайлагнана.", 4.4.2-т "Тайлант жилийн 12 сарын турш тухайн байгууллагад харьяалагдаж ажиллаагүй ажилтныг Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг суутгагч өссөн дүнгээр тооцох, зөрүүг залруулах үүрэг хүлээхгүй, санхүүгийн тайлагналын аудитын "Эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6-д "Эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

3. Тайлант оны 10, 11 дүгээр сард төслөөс цалинжсан 8 ажилтанд 130.6 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийн илүү тооцоолсон нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-т "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" Татварын ерөнхий газрын 2019 оны А/261 тоот тушаалын хавсралтын 4.4-т "Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25.5-д

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

заасны дагуу суутгагч нь мөн хуулийн 23.1-д заасан татвар ногдуулах орлого болон хөнгөлөлтийг 12 сард тэнцүү хувааж, тухайн ажилласан сард ногдох хөнгөлөлтийг эдлүүлнэ, санхүүгийн тайлагналын аудитын "Эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-т "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

5.2 Албан шаардлага

Төлбөрийн баримттай холбоотой асуудал

Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 3 иргэн, байгууллагын 475.3 мянган төгрөгөөр илүү байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй", заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын аудитын үнэлгээ, нийцсэн бөгөөд зохистой байх, хэмжилт, иж бүрэн байх, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төлбөрийн баримтын системд зөрүүтэй бүртгэсэн зөрчлийг арилгах.

Дээрх акт албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийг ерөнхий журналын цалингийн зардалтай тулган шалгахад төслийн сургалтад хамрагдсан зардал болох 4,900.0 мянган төгрөгийг цалингийн зардалд бүртгэсэн байна.	1	4,900.0			1	4,900.0	1	4,900.0				
Сангийн яамны 2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 10/84 дүгээр албан бичгийн дагуу Гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжих байгууллагын санхүүгийн тайланг орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлангаас улсын төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд шилжүүлэхтэй холбоотой санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланд тус тус 6,669,466.1 мянган төгрөгийг	1	6,669,466.1			1	6,669,466.1	1	6,669,466.1				
Дүн	2	6,674,366.1		-	2	6,674,366.1	2	6,674,366.1				

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шалгагдагч байгууллагын хүүхдийн хоолны зардлыг батлагдсан нормативаас 13,821.0 мянган төгрөгөөр илүү зарцуулсан байна.	1	13,821.0	1	13,821.0								
Шалгагдагч байгууллагын худалдан авсан хөрөнгө, материалын дүнг, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын төлбөрийн цахим системд бүртгэсэн дүнтэй тулгахад 3 иргэн, байгууллагын 475.3 мянган төгрөгөөр илүү байна.	1	475.3			1	475.3						
Тайлант онд хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлтийг 10 хүнд 190.0 мянган төгрөгөөр илүү тооцсон байна.	1	190.0	1	190.0								
Тайлант оны 10, 11 дүгээр сард төслөөс цалинжсан 8 ажилтанд 130.6 мянган төгрөгийн татварын хөнгөлөлтийн давхар тооцоолсон байна.	1	130.6	1	130.6								
Дүн	4	14,616.9	3	14,141.6	1	475.3						

Төв аймгийн Баянчандмань сумын Политехник коллеж 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсыг шалгахад 156 мэдээлэл байршуулахаас 155 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 5 удаагийн 51,419.8 мянган төгрөгийн орлого, 2 удаагийн 62,014.6 мянган төгрөгийн зарлагын гүйлгээг байршуулаагүй, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн 16 удаагийн 21,255.8 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.	1	134,690.1			1	134,690.1		
Дүн	1	134,690.1			1	134,690.1		